



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Г Далайн захиргаа байгуулах, түүний бүтэц Г  
орон тоо, дүрэм, цалин батлах тухай

Далай ашиглах тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг тус тус үндслэн ТУШААХ нь:

1. Далай болон усан замын салбарын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих Монгол Улсын Далайн захиргааг байгуулсугай.

2. Далайн захиргааны бүтцийг 1 дүгээр хавсралтаар, дүрмийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Далайн захиргааны орлогч дарга бөгөөд далайн тээвэр, усан зам, бүртгэлийн хэлтсийн даргаар /Б. Алтан-Од/-г томилсугай.

4. Далайн захиргааны дарга Д.Галсандондогийн сарын цалинг 450 \$, орлогч дарга бөгөөд далайн тээвэр, усан зам, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Алтан-Одын сарын цалинг 420 \$-оор тус тус баталсугай.

5. Далайн захиргаа байгуулагдаж байгаатай холбогдуулан үйл ажиллагаа явуулах албаны зориулалтын өрөө тасалгаагаар хангах, Хөлөг онгоцны бүртгэлийн санхүүжилтын орлого, зарлагын тооцоог хийж Далайн захиргааны дансанд төвлөрүүлэхийг Тээврийн үйлчилгээний төвийн дарга /Ч.Энхбат/-д үүрэг болгосугай.

6. Далайн захиргааны дансанд бүртгэгдэх эд хөрөнгө, автомашин, техник тоног төхөөрөмжийн жагсаалт гарган холбогдох хууль дүрмийн дагуу баталгаажуулж, орлогод аван ашиглалтад нь хяналт тавьж, бүртгэлийн хураамжийн санхүүжилтийг зохих журмын дагуу хувиарлан зарцуулж, жил бүр тайлагнаж байхыг Далайн захиргааны дарга /Д.Галсандондог/-т үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан сайдын 146 дугаар тушаалын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



САИД

Ц.ЦЭНГЭЛ